БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Эрдэнэцогт сумын Цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

**Аудитын код: БНА-2022/93/НА-СТА-ТШЗ**

Баянхонгор
2022 он


Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
Тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат

Утас: 99007576 Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn

Аудитын менежер: А.Цээням

Утас: 99442140 Цахим хаяг: tseenyama@audit.gov.mn

Аудитор: В.Наранцэцэг

Утас: 89992463 Цахим хаяг: Naraaa_2463@yahoo.com

Цахим хуудас: www.audit.mn

## Агуулга

1. Аудитын гэрчилгээ /эх хувь/ ........ 3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл ........ 5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан ........ 5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан ........ 6
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан ........ 7
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан ........ 9
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан ........ 9
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн тайлан ........ 11
3. Аудитын тайлан ........ 11
3.1 Ерөнхий зүйл ........ 11
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт ........ 12
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал ........ 12
3.4 Материаллаг байдал ........ 12
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга ........ 13
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв ........ 14
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг ........ 14
3.8 Аудитын гол асуудал ........ 15
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал ........ 15
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт ........ 15
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт ........ 16
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал ........ 16
4. Аудитын илрүүлэлт ........ 16
4.1. Албан шаардлага. ........ 16
4.2. Залруулсан алдаа ........ 16
4.3. Зөвлөмж ........ 17
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл ........ 17

## Товчилсон үгийн жагсаалт

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| ТӨБЗГ | Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар |

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
Номгон 1 дүгээр баг, Баянхонгор сум,
Баянхонгор аймаг, 64101
Утас, факс 7044 2584
E-mail; bayankhongor@audit.gov.mn

2022.02.24 № 2/95

танай ______________ -ны № ______________ -т

БАЯНХОНГОР АЙМГИЙН
ЭРДЭНЭЦОГТ СУМЫН ЦЭЦЭРЛЭГИЙН
ЭРХЛЭГЧ Ж.СОДНОМЧИМЭГ ТАНАА

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

**Зөрчилгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баянхонгор аймгийн Эрдэнэцогт сумын Цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Баянхонгор аймгийн Эрдэнэцогт сумын Цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Б.МӨНХБАТ

# 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

## 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

**СТ-1А**

**САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН**

/Төгрөгөөр/

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **68.514.779.87** | **69.928.159.58** |
| **33** | **АВЛАГА** | 2.562.713.97 | 560.450.28 |
| 33100 | Ажиллагчидтай холбогдсон авлага | 510.550.97 | 520.550.97 |
| **335** | **Бусад авлага** | 2.052.163.00 | 39.899.31 |
| 3351 | Байгууллагаас авах авлага | 2.052.163.00 | 39.899.31 |
| **34** | **УРЬДЧИЛГАА** | 00.00 | 100.000.00 |
| **3471** | **Урьдчилгаа тооцоо** | 00.00 | 100.000.00 |
| 34713 | Цалингийн урьдчилгаа | 00.00 | 100.000.00 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 65.952.065.90 | 69.267.709.30 |
| **351** | **Түүхий эд материал** | 00.00 | 2.118.400.00 |
| 35130 | Эм боох материал | 00.00 | 2.118.400.00 |
| **354** | **Хангамжийн материал** | 65.952.065.90 | 67.149.309.30 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 499.500.00 | 914.000.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 62.787.302.90 | 61.009.259.30 |
| 35460 | Хүнсний материал | 1.640.263.00 | 4.201.050.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 1.025.000.00 | 1.025.000.00 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **921.337.544.97** | **911.675.929.55** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 921.337.544.97 | 911.675.929.55 |
| **392** | **Биет хөрөнгө** | 913.857.544.97 | 904.195.929.55 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 969.395.186.90 | 969.395.186.90 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | -82.181.416.01 | -98.331.983.69 |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 27.101.514.00 | 26.608.650.00 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | -16.404.401.02 | -10.323.834.80 |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 41.595.738.00 | 34.280.200.00 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | -27.558.076.90 | -19.341.288.86 |
| 39217 | Ном | 1.909.000.00 | 1.909.000.00 |
| **393** | **Биет бус хөрөнгө** | 7.480.000.00 | 7.480.000.00 |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 7.480.000.00 | 7.480.000.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **989.852.324.84** | **981.604.089.13** |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | **2.074.167.00** | **1.259.147.00** |
| **41** | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | 2.074.167.00 | 1.259.147.00 |
| **413** | **Өглөг** | 2.074.167.00 | 1.259.147.00 |
| 41310 | Ажилчидтай холбогдсон өглөг | 31.066.00 | 1.259.147.00 |
| 41320 | Бараа үйлчилгээний зардлын өглөг | 1.362.800.00 | 00.00 |
| **4136** | **Бусад өглөг** | 680.301.00 | 00.00 |
| 41361 | Байгууллагад төлөх өглөг | 680.301.00 | 00.00 |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **987.778.157.84** | **980.344.942.13** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 987.778.157.84 | 980.344.942.13 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 100.436.916.11 | 100.436.916.11 |
| 51101 | Өмч: - төрийн | 100.436.916.11 | 100.436.916.11 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | -10.710.716.69 | -16.894.732.40 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | -10.710.716.69 | -9.461.516.69 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | -7.433.215.71 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 898.051.958.42 | 896.802.758.42 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **989.852.324.84** | **981.604.089.13** |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

**СТ-2А**

**САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН**

/Төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **293.617.870.00** | **291.267.215.25** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **12.384.662.00** | **235.000.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 12.384.662.00 | 235.000.00 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 12.384.662.00 | 235.000.00 |
| 120042 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 00.00 | 21.000.00 |
| 120045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 12.384.662.00 | 00.00 |
| **120017** | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | | 214.000.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **281.233.208.00** | **291.032.215.25** |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 251.670.600.00 | 267.273.800.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 5.951.108.00 | 3.789.530.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 5.951.108.00 | 3.789.530.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 23.611.500.00 | 19.968.885.25 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 23.611.500.00 | 19.968.885.25 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **284.128.597.05** | **298.490.057.63** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **284.128.597.05** | **298.490.057.63** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 276.279.175.05 | 285.480.922.63 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 186.485.583.00 | 190.794.043.00 |
| 210101 | Үндсэн цалин | 131.261.423.00 | 168.566.486.00 |
| 210102 | Нэмэгдэл | 43.347.249.00 | 19.019.065.00 |
| 210104 | Урамшуулал | 11.876.911.00 | 00.00 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 00.00 | 3.208.492.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 23.361.721.00 | 25.412.878.69 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 15.820.121.00 | 24.757.320.69 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 1.900.808.00 | 00.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 1.520.646.00 | 00.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 372.010.00 | 00.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 3.748.136.00 | 655.558.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 19.478.376.00 | 18.606.085.25 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 1.311.768.00 | 1.085.765.25 |
| 210302 | Түлш, халаалт | 17.757.608.00 | 17.026.020.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 409.000.00 | 494.300.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 5.776.679.00 | 17.842.707.60 |
| 210401 | Бичиг хэрэг | 624.500.00 | 800.010.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 2.593.980.00 | 1.656.750.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1.120.499.00 | 885.630.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 52.300.00 | 00.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 108.100.00 | 387.900.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 1.277.300.00 | 4.281.897.00 |
| 210408 | Бараа материал акталсны зардал | 00.00 | 9.830.520.60 |
| **2105** | **Нормативт зардал** | 14.537.770.00 | 12.419.546.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 172.500.00 | 214.000.00 |
| 210502 | Хоол, хүнс | 14.365.270.00 | 12.205.546.00 |

| | | | |
|---|---|---|---|
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 200.000.00 | 00.00 |
| 210604 | Урсгал засвар | 200.000.00 | 00.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 96.000.00 | 00.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 96.000.00 | 00.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 6.874.508.00 | 1.056.720.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 6.624.508.00 | 535.110.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 250.000.00 | 350.000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 00.00 | 171.610.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 19.468.538.05 | 19.348.942.09 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 00.00 | 1.076.900.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 611.000.00 | 00.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 18.857.538.05 | 18.272.042.09 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 7.849.422.00 | 13.009.135.00 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 104.000.00 | 3.789.530.00 |
| 213204 | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | 00.00 | 3.789.530.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 104.000.00 | 00.00 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | 4.145.624.00 | 00.00 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 4.145.624.00 | 00.00 |
| **2135** | **Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 3.599.798.00 | 9.219.605.00 |
| 213503 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 3.599.798.00 | 9.219.605.00 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **9.489.272.95** | **-7.222.842.38** |
| **225** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН** | 815.944.12 | 210.373.33 |
| 225001 | Үндсэн хөрөнгө худалдсаны гарз | 815.944.12 | 210.373.33 |
| **4** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)** | -815.944.12 | -210.373.33 |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **8.673.328.83** | **-7.433.215.71** |

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

**СТ-2А**

**МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН**

/Төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **281.233.208.00** | **291.053.215.25** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **00.00** | **21.000.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 00.00 | 21.000.00 |
| **120004** | **Төсөв байгууллагын өөрийн орлого** | 00.00 | 21.000.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 00.00 | 21.000.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **281.233.208.00** | **291.032.215.25** |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 251.670.600.00 | 267.273.800.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 5.951.108.00 | 3.789.530.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 5.951.108.00 | 3.789.530.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 23.611.500.00 | 19.968.885.25 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 23.611.500.00 | 19.968.885.25 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **276.638.308.00** | **282.232.415.25** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **276.638.308.00** | **282.232.415.25** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **268.788.886.00** | **269.223.280.25** |

| | | | |
|---|---|---|---|
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 184.009.495.00 | 191.963.504.00 |
| 210101 | Үндсэн цалин | 128.495.562.76 | 139.361.393.00 |
| 210102 | Нэмэгдэл | 25.403.969.32 | 22.942.514.00 |
| 210104 | Урамшуулал | 29.443.802.92 | 27.561.880.00 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 666.160.00 | 2.097.717.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 24.753.900.00 | 23.165.236.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 17.419.500.00 | 16.562.046.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 1.833.600.00 | 1.551.793.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 1.466.900.00 | 1.325.180.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 366.700.00 | 329.523.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 3.667.200.00 | 3.396.694.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 19.265.876.00 | 19.968.885.25 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 1.311.768.00 | 1.085.765.25 |
| 210302 | Түлш, халаалт | 17.545.108.00 | 18.388.820.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 409.000.00 | 494.300.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 5.649.579.00 | 9.388.184.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 87.500.00 | 1.589.010.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 2.593.980.00 | 1.735.550.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1.383.499.00 | 1.357.240.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 52.300.00 | 310.500.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 534.500.00 | 165.000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 997.800.00 | 4.230.884.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 19.864.430.00 | 16.169.471.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 1.842.500.00 | 335.000.00 |
| 210502 | Хоол, хүнс | 14.852.930.00 | 14.914.471.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 3.169.000.00 | 920.000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 6.264.500.00 | 4.039.200.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 4.911.500.00 | 1.310.000.00 |
| 210602 | Тавилга | 00.00 | 659.200.00 |
| 210604 | Урсгал засвар | 1.353.000.00 | 2.070.000.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 96.000.00 | 00.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 96.000.00 | 00.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 7.048.108.00 | 1.257.000.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 6.798.108.00 | 667.000.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 250.000.00 | 350.000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 00.00 | 240.000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 1.836.998.00 | 3.271.800.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 00.00 | 2.831.800.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 1.836.998.00 | 440.000.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **7.849.422.00** | **13.009.135.00** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 104.000.00 | 3.789.530.00 |
| 213204 | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | 00.00 | 3.789.530.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 104.000.00 | 00.00 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | 4.145.624.00 | 00.00 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 4.145.624.00 | 00.00 |
| **2135** | **Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 3.599.798.00 | 9.219.605.00 |
| 213503 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 3.599.798.00 | 9.219.605.00 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | **4.594.900.00** | **8.820.800.00** |
| **5** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)** | **4.594.900.00** | **8.820.800.00** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **4.594.900.00** | **8.820.800.00** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | 4.594.900.00 | 8.820.800.00 |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 4.594.900.00 | 8.820.800.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 6 | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)** | -4.594.900.00 | -8.820.800.00 |
| 7 | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | 0.00 | 0.00 |
| 8 | **МӨНГӨ ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГИЙН ЭХНИЙ ҮЛДЭГДЭЛ** | 0.00 | 0.00 |
| 9 | **МӨНГӨ ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГИЙН ЭЦСИЙН ҮЛДЭГДЭЛ** | 0.00 | 0.00 |

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

**СТ-4А**

**ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН**

/ төгрөгөөр /

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Бусад | Засгийн газрын хувь оролцооний нийт дүн |
|---|---|---|---|---|---|---|
| C08 | **2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **100.436.916.11** | **898.051.958.42** | **-10.710.716.69** | **00.00** | 987.778.157.84 |
| D01 | **2021 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл** | **100.436.916.11** | **898.051.958.42** | **-10.710.716.69** | **00.00** | 987.778.157.84 |
| D02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 00.00 | 00.00 | 1.249.200.00 | 00.00 | 1.249.200.00 |
| D03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **100.436.916.11** | **898.051.958.42** | **-9.461.516.69** | **00.00** | 989.027.357.84 |
| D04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт | 00.00 | -1.249.200.00 | 00.00 | 00.00 | -1.249.200.00 |
| D08 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 00.00 | -7.433.215.71 | 00.00 | -7.433.215.71 |
| D09 | **2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **100.436.916.11** | **896.802.758.42** | **-16.894.732.40** | **00.00** | 980.344.942.13 |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

ТГ

**ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН**

**/ төгрөгөөр /**

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Тайлант оны | |
|---|---|---|---|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл |
| **1** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 291,057,100.00 | 278,023,080.25 |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 291,057,100.00 | 278,023,080.25 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 290,960,800.00 | 278,023,080.25 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 198,417,000.00 | 191,942,504.00 |
| 210101 | Үндсэн цалин | 139,011,800.00 | 139,340,393.00 |
| 210102 | Нэмэгдэл | 24,526,200.00 | 22,942,514.00 |
| 210104 | Урамшуулал | 30,523,200.00 | 27,561,880.00 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 4,355,800.00 | 2,097,717.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 25,213,500.00 | 23,165,236.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210201 | Тэтгэврийн даатгал | 16,115,700.00 | 16,562,046.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 3,156,000.00 | 1,551,793.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 1,604,800.00 | 1,325,180.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 394,200.00 | 329,523.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 3,942,800.00 | 3,396,694.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 23,783,300.00 | 19,968,885.25 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 2,371,100.00 | 1,085,765.25 |
| 210302 | Түлш, халаалт | 20,912,200.00 | 18,388,820.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 500,000.00 | 494,300.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 9,833,800.00 | 9,778,184.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 1,586,600.00 | 1,589,010.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 1,700,000.00 | 1,735,550.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,377,400.00 | 1,357,240.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 348,100.00 | 310,500.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 180,000.00 | 165,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 4,641,700.00 | 4,620,884.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 16,247,800.00 | 16,169,471.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 344,900.00 | 335,000.00 |
| 210502 | Хоол, хүнс | 14,971,400.00 | 14,914,471.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 931,500.00 | 920,000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 12,647,600.00 | 12,470,000.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 7,500,000.00 | 7,450,000.00 |
| 210602 | Тавилга | 3,000,000.00 | 2,950,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 2,147,600.00 | 2,070,000.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 89,800.00 | 00.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 89,800.00 | 00.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 1,268,000.00 | 1,257,000.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 678,000.00 | 667,000.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 350,000.00 | 350,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 240,000.00 | 240,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 3460000.00 | 3271800.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 2,990,000.00 | 2,831,800.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 470,000.00 | 440,000.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 96300.00 | 0.00 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 96,300.00 | 00.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 96,300.00 | 00.00 |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 291,057,100.00 | 278,023,080.25 |
| **1310** | **УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 267,273,800.00 | 258,054,195.00 |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 267,273,800.00 | 258,054,195.00 |
| **1320** | **ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 23,783,300.00 | 19,968,885.25 |
| 132001 | Орон нутгийн төсвөөс | 23,783,300.00 | 19,968,885.25 |
| **62** | **АЖИЛЛАГСАДЫН ТОО** | 19 | 19 |
| 620001 | Удирдах ажилтан | 01 | 01 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 11 | 11 |

| | | | |
|---|---|---|---|
| 620003 | Үйлчлэх ажилтан | 07 | 07 |
| **631** | **СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛЫН БАЙГУУЛЛАГА** | 90.00 | 90.00 |
| 631001 | Төрийн өмчит СӨБ байгууллага | 90.00 | 90.00 |
| **65** | **ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ** | **19.00** | **19.00** |
| 650004 | СЄБ болон бага, дунд боловсролын албан хаагч (ТҮБД) | 12.00 | 12.00 |
| 650009 | Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ) | 07.00 | 07.00 |

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн тайлан

**НТ-2**

**НЭМЭЛТ САНХҮҮЖИЛТИЙН ТАЙЛАН**

/ төгрөгөөр /

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх он | Гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **I** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **5.951.508.00** | **3,789,530.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **5.951.508.00** | **3,789,530.00** |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | **5.951.508.00** | 3,789,530.00 |
| **II** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | **5.951.508.00** | 3,789,530.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | **5.951.508.00** | 3,789,530.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | **5.951.508.00** | 3,789,530.00 |
| **IV** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)** | **0.00** | **0.00** |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | **0.00** | **0.00** |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | **0.00** | **0.00** |

## 3. Аудитын тайлан

### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Эрдэнэцогт сумын Цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газартай хийсэн гэрээний үндсэн дээр "Глобал капитал аудит" ХХК-ийн аудитор В.Наранцэцэг гүйцэтгэж, чанарын хяналтыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор М.Алтантуяа, аудитын менежер А.Цээням, Газрын дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат нар тус тус хэрэгжүүлсэн.

Эрдэнэцогт сумын Цэцэрлэг нь 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийх хүсэлтийг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 11-ны өдрийн 04 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

Санхүүгийн тайлант хугацаанд Цэцэрлэгийн эрхлэгч Ж.Содномчимэг нэгдүгээр гарын үсгийг, нягтлан бодогч Ж.Оюунтуяа нар хоёрдугаар гарын үсгийг тус тус зурж хөрөнгө мөнгийг захиран зарцуулсан байна.

### 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Эрдэнэцогт сумын Цэцэрлэг нь бага насны хүүхдийг асрах, хамгаалах, хүмүүжүүлэх, сургах цогц үйл ажиллагаагаар хүүхдийн бие бялдар, оюун ухаан, нийгэмшихүйн хөгжлийг дэмжих, сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээг хүргэх зорилго зорилтыг хангах үүднээс сургуулийн өмнөх боловсролын үйл ажиллагааг хэвийн явуулах чиг үүргийг хэрэгжүүлж ажиллаж байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг байхгүй.

Тус байгууллага нь дотоод аудитын алба байхгүй бөгөөд дотоод аудитын чиг үүргийг аймгийн Санхүүгийн хяналт аудитын алба нь хэрэгжүүлдэг ба Эрдэнэцогт сумын Цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийгдээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Эрдэнэцогт сумын Цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### 3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд төлөвлөлтийн үе шатны материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл "Дунд" гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны үр дүнгийн тайлангийн нийт зардал 283,050.5 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 4,245.7 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 3,184.3 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин гүйцэтгэлийн үе шатанд хянаж үзэхэд 2021 оны үр дүнгийн тайлангийн нийт зардлаас тооцоход 3,358.0 мянган төгрөг байгаа тул шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Эрдэнэцогт сумын Цэцэрлэгийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгө 981,604.1 мянган төгрөг болж өмнөх оноос 8,248.2 мянган төгрөгөөр буюу 0,8 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан авлага, бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

*Хүснэгт 1.* Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт /мянган төгрөг/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН | 68.514.8 | 69.928.2 | 1.413.4 |
| Мөнгөн хөрөнгө | - | - | - |
| Авлага | 2.562.7 | 560.5 | (2.002.3) |
| Урьдчилгаа | - | 100.0 | 100.0 |
| Бараа материал | 65.952.1 | 69.267.7 | 3.315.6 |
| ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН | 921.337.5 | 911.675.9 | (9.661.6) |
| Үндсэн хөрөнгө | 1.047.481.4 | 1.039.673.0 | (7.808.4) |
| Хуримтлагдсан элэгдэл | (126.143.9) | (127.997.1) | (1.853.2) |
| **Нийт хөрөнгө** | 989.852.3 | 981.604.1 | (8.248.2) |
| Өр төлбөр | 2.074.2 | 1.259.1 | (815.0) |
| Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/ | 987.778.2 | 980.344.9 | (7.433.2) |
| **Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн** | 989.852.3 | 981.604.1 | (8.248.2) |

Эх сурвалж.Санхүүгийн тайлан

Бараа материалын дансны үлдэгдэл 69,267.7 мянган төгрөг болж 3,315.6 мянган төгрөгөөр өссөн нь аж ахуйн материал 1,778.1 мянган төгрөг, эм боох материал 2,118.1 мянган төгрөгөөр өссөн нь голлох нөлөөг үзүүлж байна.

Авлага данс оны эхэнд 2,560.7 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байснаас 2,002.3 мянган төгрөгийн авлагыг барагдуулсан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 1,039,673.0 мянган төгрөг болж 7,808.4 мянган төгрөгөөр буурсан нь төсвийн хөрөнгөөр 6,000.8 мянган төгрөгөөр тоног төхөөрөмж, 2,820.0 мянган төгрөгийн тавилга эд хогшил **/номын тавиур, хувцасны шкаф, гэрийн эд хогшил/** худалдан авч,Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2021.12.28-ний 156 тоот тогтоолоор 6,493.6 мянган төгрөгийн тоног төхөөрөмж,10,135.5 мянган төгрөгийн тавилга эд хогшил акталсантай холбоотой байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 980,344.9 мянган төгрөг болж өмнөх оноос 7,433.2 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүнгийн өөрчлөлтөөс шалтгаалжээ.

### 3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй. Тус байгууллагын нэмэлт санхүүжилтийн дансаар 3,789.5 мянган төгрөгийн орлого, зарлагын гүйлгээ хийгдсэн байна.

### 3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 334,920.5 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 334,920.5 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 15,791.6 мянган төгрөгөөр бууруулж 350,712.1 мянган төгрөгөөр батлагдсан ба аймгийн Засаг даргын 2021.05.06-ний А/289 тоот, 2021.12.06-ны А/742 тоот захирамжуудаар төсвийн зохицуулалт хийгдэж 291,057.1 мянган төгрөгөөр тайлант жилийн төсөв батлагдсан байна.

### 3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 8 арга хэмжээг санхүүжүүлэхээр 291,057.1 мянган төгрөгийн төсөв баталснаас улсын төсвөөс 267,273.8 мянга төгрөг, орон нутгийн төсвөөс 23,783.3 мянган төгрөгийг санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 267,273.8 мянга, орон нутгийн төсвөөс 19,968.8 мянга нийт 287,242.6 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 278,023.1 мянган төгрөгийг зарцуулж 9,219.6 мянган төгрөг буюу 3.2 хувийг улсын төсөвт буцаан төвлөрүүлж, орон нутгийн төсвөөс авах санхүүгийн дэмжлэгийг 3,814.4 мянган төгрөгөөр дутуу авсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 278,023.0 мянган төгрөг буюу 95.5 хувьтай байгаа нь цалингийн зардлыг 6,474.4 мянган төгрөг,тогтмол зардлыг 3,814.1 мянган төгрөгөөр хэмнэсэнтэй холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тус байгууллагын нэмэлт санхүүжилтийн дансаар хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласны тэтгэмжид 3,789,5 мянган төгрөгийг зохих журмын дагуу зарцуулсан байна.

### 3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Тайлант онд Ковид-19 цар тахалтай холбоотой цэцэрлэгийн үйл ажиллагаа БШУЯ, улсын болон аймгийн онцгой комиссоос өгсөн шийдвэр, чиглэлийн дагуу тусгай горимоор хичээллэсэн.

Тус байгууллагын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд Баян ташаагийн эх аудит ХХК-ийн аудитор Ч.Чимгээ аудит хийсэн бөгөөд тайлант оны санхүүгийн тайлангийн аудитаар өмнөх оны санхүүгийн тайлангийн мэдээллийг хамруулаагүй болно.

Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 4 зорилт 25 ажил төлөвлөснөөс 97,0 хувьтай хэрэгжсэн гэж тайлагнасан.

### 3.8 Аудитын гол асуудал

Тус байгууллагын санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт зардал 298,490.1 мянган төгрөг байгаа нь өмнөх оноос 14,361.5 мянган төгрөгөөр буюу 4,9 хувиар өссөн байна.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан зардлууд нь цалин, НДШ-ийн зардал, хангамж, бараа материалын зардал өсөж, нормативд зардал буурсан үзүүлэлттэй байна.

### 3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

#### 3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан Монгол Улсын Ерөнхий аудиторын 2021 оны А/108 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагаас шилэн дансны 2021-2022 оны үйл ажиллагаанд хөндлөнгийн хяналтыг хэрэгжүүлэх ерөнхий чиглэл”-ийн 1 дүгээр хавсралтад заасан 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Тайлант хугацаанд шилэн дансны мэдээллийн сайтад оруулбал зохих 151 мэдээллээс хугацаа болоогүй 2 мэдээлэл , мэдээлбэл зохих 149 мэдээллээс Төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт, хэмнэлтийн шалтгааны тайлбарын сарын мэдээллийг 1 удаа, улирлын мэдээллийг 2 удаа, Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээний 9741.9 мянган төгрөгийн 1 мэдээлэл, Санхүүгийн тайлангийн хагас жилийн 1 мэдээлэл, тухай бүр мэдээлэх Хөрөнгийн болон урсгал зардалд тусгагдсан арга, хэмжээний тендерийн ерөнхий мэдээллийг 1 удаа, хөрөнгийн зардал,хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл, концессын зүйлийн жагсаалт, гүйцэтгэлийн мэдээллийг 1 удаа, нийт 4 төрлийн 9,741.9 мянган төгрөгийн 7 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.

#### 3.9.2 Засгийн газрын 2021 оны “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоолын хэрэгжилт

Тайлант онд тогтмол зардалд анхны батлагдсан төлөвлөгөөгөөр 24,918.3 мянган төгрөг ба батлагдсан төсвийн 20 хувь нь 4,983.7 мянган төгрөг байна.

Төсвийн зохицуулалтаар 1,135.0 мянган төгрөгөөр хассан, гүйцэтгэлээр 3,814.4 мянган төгрөгийн хэмнэлт, нийт 4,949.4 мянган төгрөгийн хэмнэлт үүссэн байгаа нь Засгийн газрын 2021 оны "Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоолын "1.8. байгууллагын цахилгаан, дулааны эрчим хүч, цэвэр усны хэрэглээнд 20-иос доошгүй хувийн хэмнэлт гаргах" гэсэн заалттай нийцэж байна.

### 3.9.3. Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл тайлант хугацаанд төсвийн хөрөнгөөр 61,871.3 мянган төгрөгийн хүүхдийн хоол худалдан авах ажиллагааг сумын ЗДТГ зохион байгуулсан байна .

### 3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх аудитаар зөрчилгүй дүгнэлт авсан, аудитаар илэрсэн 1520.0 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрч 2 зөвлөмж өгсөн. Зөвлөмжийн хэрэгжилтийг 2021.06.17-ны өдрийн 12 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

### 3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Байхгүй

## 4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 4,064.2 мянган төгрөгийн 5 алдаа зөрчил илэрч, 3,040.6 мянган төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага өгч, 1,023.6 мянган төгрөгийн 3 алдааг залруулж, зөрчлийг арилгах 1 зөвлөмж хүргүүлэв.

### 4.1. Албан шаардлага.

**4.1.1.**Тайлант онд Нийгмийн даатгалын хэлтэст 3 ажилтны цалингийн санг 2,853.9 мянган төгрөгөөр дутуу, 3 ажилтны цалингийн санг 186.7 мянган төгрөгөөр илүү, нийт цалингийн санг 3,040.6 мянган төгрөгөөр зөрүүтэй мэдээлсэн нь Нийгмийн даатгалын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.1 дэх "ажил олгогч нь хөдөлмөрийн хөлсний сан, түүнтэй адилтгах орлого болон түүнд оногдох шимтгэлийг үнэн зөв тодорхойлж, тогтоосон хугацаанд төлөх" гэсэн заалтыг зөрчсөн, санхүүгийн тайлангийн "Нийцсэн бөгөөд зохистой байх" гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

**Шийдвэрлэсэн нь**: Нийгмийн даатгалын хэлтэст зөрүүтэй мэдээлсэн ажилчдын 2021 оны 3,040.6 мянган төгрөгийн цалинг залруулан мэдээлж зөрчлийг арилгах албан шаардлага

### 4.2. Залруулсан алдаа

**4.2.1** Горим сорил гүйцэтгэх явцад дараах алдаа илрэв. Үүнд:

- Санхүүгийн тайлангийн Эм ороох боох материалын орлого 193.6 мянган төгрөгөөр, зарлага 36.8 мянган төгрөгөөр нярвын тайлангаас зөрүүтэй/ **нярав 2 дахин орлого авсан/**

-Санхүүгийн тайлангийн аж ахуйн материалын орлого нярвын тайлангаас 343.0 мянга, зарлага 368.9 мянган төгрөгөөр зөрүүтэй бүртгэсэн.

-Санхүүгийн тайлангийн түлш шатахууны орлого нярвын тайлангаас 27.9 мянга, зарлага 53.5 мянган төгрөгөөр тус тус зөрүүтэй бүртгэсэн байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв

гаргах үндэслэл болно, санхүүгийн тайлангийн "Үнэлгээ ба хуваарилалт" , " Үнэн зөв байх" гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

**Шийдвэрлэсэн нь**: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1."Аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэл хөтлөлтөд гарсан алдааг алдаа гарсан шалтгаан, залруулах аргыг тодорхой тусгасан баримт, тайланг үндэслэн залруулах бөгөөд зөвшөөрсөн болон залруулга хийсэн албан тушаалтан гарын үсэг зурж баталгаажуулна." гэснийг үндэслэн нярвын материалын тайланг засуулж дахин гаргуулав.

## 4.3. Зөвлөмж

**4.3.1**.Тайлант хугацаанд шилэн дансны мэдээллийн сайтад оруулбал зохих 151 мэдээллээс хугацаа болоогүй 2 мэдээлэл , мэдээлбэл зохих 149 мэдээллээс нийт 4 төрлийн 9,741.9 мянган төгрөгийн 7 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар 6.3.2.төсвийн гүйцэтгэлийг батлагдсан төсвийн төлөвлөгөөтэй харьцуулсан харьцуулалт , 6.3.6.хөрөнгийн болон урсгал зардалд тусгагдсан арга хэмжээг тендер зарлаж, сонгон шалгаруулсан бол шалгаруулалтын ерөнхий мэдээлэл; 6.3.7.хөрөнгө оруулалтын зарлага, санхүүжилтийг төсөл, объект тус бүрээр гэсэн заалтыг тус тус зөрчсөн байна.

**Шийдвэрлэсэн нь:** Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан хуулийн цаглаварт хугацаанд мэдээллийг бүрэн, үнэн зөв мэдээлж байх

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| д/д | Аудитад хамрагдсан байгууллагын нэр | Нийт алдаа, зөрчлийн | | Үүнээс | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Залруулга | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| 1 | Эрдэнэцогт сумын Цэцэрлэг | 5 | 4,064.2 | 3 | 1,023.6 | 0 | 0,00 | 1 | 3,040.6 | 1 | |

______oOo______